



TransBank
ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК

**ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН
ТАЙЛАН Б.ОЮУНЦАЦРАЛ**

2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр
Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр хөгжлийн банк ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” болон Банкны Дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2025 оны 1 дүгээр улирал буюу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 6 удаа хуралдсан бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 1-р сарын 20-ны өдрийн хурлаар
 - Эрсдэлийн удирдлагын нэгдсэн тайлан /2024 оны 4 улирлын байдлаар/
 - Тусгай активын нэгжийн гүйцэтгэлийн тайлан
 - Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, 2025-2029 оны төлөвлөгөө
 - Зээлийн бодлого, эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд өөрчлөлт оруулах санал
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 1-р сарын 21-ний өдрийн хурлаар
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
 - Гүйцэтгэх удирдлагын ажлын тайлан /2024 оны 4 дүгээр улирал/
 - Хүний нөөц, цалин урамшууллын судалгаа
 - 2024 оны гүйцэтгэлийн урамшуулал олгох эсэх тухай
 - Макро эдийн засгийн төлөв 2025 он
 - Банкны 2025 оны бизнес төлөвлөгөө, төсвийн талаарх асуудлуудыг хэлэлцэж батлахад дэмжсэн саналтайгаар оролцсон.
 - Банкны бүтэц зохион байгуулалт, орон тооны талаарх саналтай танилцаж, гүйцэтгэх захирлын шууд удирдлагад хяналт шалгалтын нэгж шинээр

байгуулах, мөн комплаенсийн нэгжийг харьяалуулах саналтайгаар тус бүтэц зохион байгуулалт, орон тоо батлах асуудалд түдгэлзсэн санал өгсөн.

- Дотоод аудитын газрын 2025 оны бүтэц, орон тоо, төсөв, ажлын төлөвлөгөө
 - Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх тайлан
 - 2024 оны хөрөнгийн тооллогын танилцуулга
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай асуудлуудтай танилцаж, дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2-р сарын 21-ний өдрийн хурлаар
 - Дотоод аудитын газрын Мэдээллийн технологийн аудитын хэлтсийн захирлын өөрийн гаргасан хүсэлтийн дагуу түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэхэд дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2-р сарын 24-ний өдрийн хурлаар
 - Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох саналын тухай хэлэлцэж, Хөндлөнгийн аудитын байгууллага болох “Өлзийт экаунт аудит” ХХК-г Тээвэр хөгжлийн банкны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын үйлчилгээ үзүүлэх байгууллагаар сонгож, тус хөндлөнгийн аудитын байгууллагатай гэрээ байгуулах эрхийг банкны Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбаяр/-д олгохоор шийдвэрлэхэд дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3-р сарын 25-ны өдрийн хурлаар
 - Тээвэр хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
 - Цалин шинэчлэн тогтоох тухай асуудлуудыг хэлэлцэж, тус асуудлуудад дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3-р сарын 31-ний өдрийн хурлаар

- Комплаенсийн газрын 2025 оны 1 дүгээр улирлын тайлантай танилцсан бөгөөд тус тайланг зохих журмын дагуу Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дээрх хурлуудад миний бие оролцож, зохих санал дүгнэлтийг тухай бүр гаргаж, саналын зөрүүтэй асуудлуудад өөрийн байр суурийг илэрхийлэн оролцсон болно.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
Аудитын хорооны хуралд оролцсон байдал**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр, 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдөр тус тус хуралдсан бөгөөд тус хурлуудаар нийт 3 асуудлыг хэлэлцэж, Аудитын хорооны даргын хувьд хурлыг удирдан, хурлуудаас холбогдох санал дүгнэлтийг гарган ажилласан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

- Аудитын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар:

1. Банкны дотоод аудитын газрын 2024 оны ажлын тайлан танилцуулах, 2025 оны төсөв, төлөвлөгөөний саналын тухай
2. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх тайлан /2024 оны 4 дүгээр улирлын байдлаарх/

Дээрх асуудлуудыг хэлэлцэж дараах санал дүгнэлтийг гарган гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож ажилласан. Үүнд:

- Банкны дотоод аудитын газрын 2024 оны ажлын тайлантай танилцаж, 2025 оны төсөв, төлөвлөгөөг хавсралтаар батлахад дэмжсэн саналтайгаар оролцсон бөгөөд дотоод аудитын газрын 2025 оны төсөв, төлөвлөгөөг батлах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлахаар шийдвэрлэсэн.

- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх 2024 оны 4 дүгээр улирлын байдлаарх тайлантай танилцсан.

- Аудитын хорооны 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар:

1. Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу хөндлөнгийн аудитын байгууллага сонгох асуудалтай танилцаж, банкны 2024 оны санхүүгийн хөндлөнгийн аудитын байгууллагаар “Өлзийт экаунт” ХХК-г сонгох саналыг дэмжиж, тус асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын
хорооны хуралд оролцсон байдал**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр, 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр тус тус хуралдсан бөгөөд тус хурлуудаар нийт 3 асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гаргасан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар:

1. Эрсдэлийн удирдлагын 2024 оны 4 дүгээр улирлын байдлаарх нэгдсэн тайлантай танилцсан
2. Тусгай активын нэгжийн гүйцэтгэлийн тайлантай танилцсан
3. Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөө 2025-2029-тэй тус тус танилцаж, тус төлөвлөгөөг зохих журмын дагуу Монголбанканд хүргүүлэхийг банкны Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон.
4. Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд өөрчлөлт оруулах саналтай танилцаж, хавсралт №1-т “зээлийн төвлөрлийн хязгаарлалт 2025 оны туршид нэг салбарт байршуулах зээлийн дээд хэмжээг нийт зээлийн багцын 40 хувиас хэтрүүлэхгүй байхаар хангаж ажиллана, Зээлийн бусад хязгаарлалт Зээлийн өр төлбөрт тооцож зээлдэгчээс банкны өмчлөлд шилжүүлэн авах хөрөнгийн хэмжээг нийт активын 5 хувиас хэтрэхгүй хэмжээнд хангаж ажиллана. Эрсдэлийн аппетитийн мэдэгдлийг хэмжих үзүүлэлтүүдэд 2025 оны туршид 1 салбарт олгосон нийт зээл/Нийт зээл < 40%, Борлуулах зориулалттай хөрөнгө+Өмчлөх бусад хөрөнгө Нийт актив < 5%” гэж нэмэлт өөрчлөлт оруулахаар хэлэлцсэн;
5. Зээлийн бодлогод өөрчлөлт оруулах саналтай танилцаж, Хавсралт №1-т “Банк нь зээлийн гэрээний хугацаанд эргэн төлөгдөөгүй зээл, түүний хүү болон авлага, бусад төлбөрт тооцон Зээлдэгчийн барьцаа хөрөнгө болон бусад хөрөнгийг гэрээ, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр авч үүргийн гүйцэтгэлийг хангуулж болно. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Зээлдэгчээс Банкны эзэмшил, өмчлөлд шилжүүлэн авах хөрөнгийн хэмжээ нь нийт зээлийн багцын **нийт активын** 5 хувиас хэтрэхгүй хэмжээнд байх тохиолдолд Зээлийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, биелэлтийг улирал тутам төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулна” гэж

нэмэлт өөрчлөлт оруулахаар тус тус шийдвэрлэн, эдгээр санал дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулахаар шийдвэрлэсэн.

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их
хэмжээний хэлцлийн талаар**

Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.

Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын багийн хооронд мэдээлэх процесс, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн Б.Оюунцацрал


